



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 03 өдөр

Дугаар A/62

Улаанбаатар хот

“Хүний эрх хамгаалагчийг хамгаалах механизм”, “Хүний эрх хамгаалагч гэж хэн бэ” сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь хэсэг, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.6 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын үндсэн чиг үүрэг, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Хүний эрх хамгаалагчийг хамгаалах механизм, хуулийг практикт хэрэгжүүлэх чадвар олгох, иргэд, олон нийтэд хүний эрх хамгаалагчийн соёлыг төлөвшүүлэх, хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах хандлагыг түгээн дэлгэрүүлэхэд зорилгоор “Хүний эрх хамгаалагчийг хамгаалах механизм”, “Хүний эрх хамгаалагч гэж хэн бэ” сургалт, хэлэлцүүлгийг 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулсугай.

2. “Хүний эрх хамгаалагчийг хамгаалах механизм”, “Хүний эрх хамгаалагч гэж хэн бэ” сургалт, хэлэлцүүлгийн хөтөлбөрийг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Зарцуулагдах 1,000,000 (нэг сая) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын холбогдох зардлаас гаргахыг Засаг даргын тамгын газар (Л.Санжийжамц)-т зөвшөөрсүгэй.

4. Арга хэмжээг чанар, үр дүнтэй зохион байгуулж, санхүүгийн тайланг арга хэмжээ зохион байгуулж дууссанаас хойш ажлын 7 хоногт багтаан санхүүд ирүүлэхийг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Б.Отгонжаргал)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

А.СҮХБОЛД

AJIL\2026 он ажил\захирамж

1226010195

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 04 дугаар сарын 03 -ны өдрийн
А/62 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

**“ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧИЙН ҮЙЛДЛИЙГ ХАМГААЛАХ НЬ”
СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

Сургалтын зорилго: Зорилго: Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Хүний эрх хамгаалагчийг хамгаалах механизм, хуулийг практикт хэрэгжүүлэх чадвар олгох, хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах хандлагыг төлөвшүүлэхэд чиглэнэ.

Оролцогчид: Засаг даргын тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын алба, төрийн болон төрийн захиргааны байгууллагуудын төлөөлөл

Хэзээ: 2026 оны 04 дүгээр сарын 15 -ны өдрийн 09 цаг

Хаана: Засаг даргын Тамгын газрын хурлын танхим

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР		
Хугацаа	Сэдэв	Чиглүүлэгч
09:00-09:10	Нээлт:	С.Дондов, ХЭҮК-ын гишүүн
09:10-09:55	- Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо - Хүний эрхийн Үндэсний Комиссын чиг үүрэг - Асуулт хариулт	С.Дондов, ХЭҮК-ын гишүүн
09:55-10:50	- Хүний эрх хамгаалагчийг хамгаалах механизм - Асуулт хариулт	А.Балдангомбо, Сургалт, сурталчилгаа, хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн
10:50-11:00	Цайны завсарлага	
11:00-11:45	- Хүний эрх хамгаалагчийг хамгаалах нь-Төрийн үүрэг - Асуулт хариулт	Б.Эрдэнэбат, Хүний эрх хамгаалагчийн хэлтсийн дарга
11:45-12:00	Хаалт: Сургалтын үнэлгээ	ХЭХХ

**“ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧ ГЭЖ ХЭН БЭ”
ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ХӨТӨЛБӨР**

Сургалтын зорилго: Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хүний эрх хамгаалагчийг хамгаалах тогтолцоо, Хүний эрхийн Үндэсний Комисс, Хүний эрх хамгаалагчийн хороонд гомдол, мэдээлэл гаргах тухай мэдлэг олгох, хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах хандлагыг төлөвшүүлэхэд чиглэнэ.

Сургалтад оролцогчид: Төрийн бус байгууллагууд, иргэдийн төлөөлөл

Хэзээ: 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 14 цаг

Хаана: Засаг даргын Тамгын газрын хурлын танхим

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР		
Хугацаа	Сэдэв	Чиглүүлэгч
14:00-14:10	Нээлт, Танилцах	С.Дондов, ХЭҮК-ын гишүүн
14:10-14:30	Хүний эрх хамгаалагчийн тухай ойлголт • Хүний эрхийг хамгаалагчийг тодорхойлох нь • Хүний эрх хамгаалагчийн эрх, үүрэг, хориглох зүйл	А.Балдангомбо, Сургалт, сурталчилгаа, хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн
14:30-14:50	Хүний эрх хамгаалагчийг хамгаалах нь • Хүний эрхийн Үндэсний Комисст гомдол, мэдээлэл гаргах нь • Хүний эрх хамгаалагчийн хорооны үйл ажиллагааны онцлог, гомдол мэдээлэл гаргах нь	Ц.Рэнцэндулам, Хяналт шинжилгээ, судалгаа хариуцсан референт
14:50-15:00	Цайны завсарлага	
15:00-16:30	• Чөлөөт хэлэлцүүлэг	С.Дондов, ХЭҮК-ын гишүүн
16:30-16:40	Хаалт	

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 04 сарын 03 -ны өдрийн 1162 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

ЗАРЦУУЛАГДАХ ТӨСӨВ

Д/ д	Төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүр зардал	Нийт зардал	Хянасан
1.	Ус	ш	200	1000	200,000	
2.	Кофе/цай	уут	4	25.000	100,000	
3.	Жигнэмэг	ш	200	3500	700,000	
Дүн					1,000,000	